



**Financial Education**

**КОМПЛАЕНС-  
УДИРДАХ  
АЖИЛТНЫ  
МАНЛАЙЛАЛ**

**ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА,  
ЗАХИРЛУУДАД ЗОРИУЛАВ**

Санхүүгийн боловсролын HUB

---



## КОМПЛАЕНС-УДИРДАХ АЖИЛТНЫ МАНЛАЙЛАЛ ПРАКТИКТ СУУРИЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

### Сургалтын зорилго

Монгол улсад ОУ-ын ФАТФ байгууллагаас хийсэн үндэсний эрсдэлийн үнэлгээний тайлангийн үндсэн дээр комплаенсын хэрэгжилт банкнаас бусад салбарт сул, эрсдэл өндөр, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд удирдах ажилтнуудын үүрэг оролцоо чухал гэдгийг онцолсон нь энэ удаагийн сургалтын гол чиглүүлэг бөгөөд комплаенсын зорилго, үүрэг, эрсдэлийн талаар ахисан түвшний мэдлэгийг олж аван, байгууллагадаа комплаенсын соёлыг бий болгон улмаар Монгол Улсад мөрдөгдөж буй мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, журам, дотоод хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар илүү ахисан шатны мэдлэгтэй болно.

### Зорилтот бүлэг

Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбарын холбоодын гишүүн байгууллагуудын ТУЗ, гүйцэтгэх удирдлагууд

### Сургалтын арга хэлбэр

Сургалт нь Санхүүгийн боловсролын HUB-ын туршлагатай зөвлөх, сургагч багш нарын чадавхи дээр суурилан олон улсын шилдэг практик туршлагаас суралцан, бодит кейс дээр харилцан ярилцаж, СЗХ-ны хяналт шалгалт, зохицуулалтын газартай хамтран хэлэлцүүлэг хийн, эхний 2 өдөр виртуал танхимд Zoom meeting платформ дээр явагдана. Бататгал хэлэлцүүлэг нь 2 дахь өдрийн үдээс хойш 15:00 цагт СЗХ-ны Санхүүгийн хүртээмжийн танхимд хийгдэнэ.

### Сургалтын онцлог

Сургалтын эцэст бататгал хэлэлцүүлэг хийнэ. Хэлэлцүүлэгт СЗХ-ны ХШЗГ-ын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх албаны удирдлагууд болон мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл оролцоно.

Сургалтад оролцсон нийт ажилтанд СЗХ-ны сургалтын журмын 2.3.7 болон 2.4.2 дэх заалтад заасан мэргэшүүлэх сургалтад хамрагдсан сертификат олгоно.

### Сургалтад тавигдах шаардлага

Комплаенсын анхан шатны сургалтад хамрагдсан бол давуу тал болно.

### Сургагч багш нар

Р.Амаржаргал / Санхүүгийн боловсролын HUB УЗ-ийн дарга, МУ-ын ерөнхий сайд асан/

Д.Цолмон / ММФ ТУЗ-ийн дарга, Зөвлөх хорооны дарга /

А.Авир /СЗХ-ны ХШЗГ-ын КЗКХ-ийн дарга/

Г.Даваахүү /СМА-ны бодлогын хэлтсийн дарга/

Ш.Алтанцэцэг / Санхүүгийн боловсролын HUB зөвлөх, сургагч багш /

Ч.Зоригтбаатар /Хуульч, өмгөөлөгч, сургагч багш/

### Сургалтын огноо



2023 оны 11-р сарын 28-29-ны өдрүүдэд 10:00-13:00 цаг хооронд Зоом платформоор, Бататгал хэлэлцүүлэг 29-ны өдрийн 15:00 цагт танхимд хийгдэнэ.

### Анхаарах зүйл

Сургалт эхлэхээс 15 минутын өмнө холбогдсон байх бөгөөд камерыг сургалтын турш нээлттэй байлгана.

## Эхний өдрийн хөтөлбөр

Цаг	Сэдэв	Агуулга	Сургагч багш
10:00-10:10	Нээлт	Сургалтын зорилго Санхүүгийн боловсролын HUB байгууллагын танилцуулга	Д.Оюунгэрэл Санхүүгийн боловсролын HUB Гүйцэтгэх захирал
10:10-11:10	Комплаенсыг хэрэгжүүлэхэд болон МУТС урьдчилан сэргийлэхэд удирдах албан тушаалтны үүрэг оролцоо	Комплаенсын зорилго, үүрэг, эрсдэл, удирдах ажилтны үүрэг оролцоо	Д.Цолмон Санхүүгийн боловсролын HUB Зөвлөх хорооны дарга
11:10-11:20	<b>Цайны завсарлага</b>		
11:20-12:10	Комплаенс, Мөнгө угаалт эдийн засгийн хөгжилд нөлөөлөх нь	Удирдах ажилтны манлайлал-Комплаенсын хэрэгжилт, МУТСТ тогтолцоо	Г.Даваахүү СМА-ны хэлтсийн дарга Санхүүгийн боловсролын HUB, сургагч багш
12:10-13:00	Комплаенсыг хэрэгжүүлэхэд болон МУТС урьдчилан сэргийлэхэд удирдах албан тушаалтны үүрэг оролцоо	Комплаенсын хэрэгжилтэд засаглалын үүрэг, харилцан хамаарал	А.Авир СЗХ-ны КЗКХэлтсийн дарга

## Хоёр дахь өдөр

Цаг	Сэдэв	Агуулга	Сургагч багш
10:00-11:30	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, хууль эрх зүйн зохицуулалт, түүний үр нөлөө	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог ойлгон, МУ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, Монголбанк СМА болон Санхүүгийн Зохицуулах Хороо зэрэг эрх бүхий	Ч.Зоригтбаатар Хуульч, өмгөөлөгч Сургагч багш



		байгууллагаас баталсан эрх зүйн баримт бичгийг удирдах ажилтны зүгээс хэрхэн хэрэгжүүлж, хяналт тавих	
<b>11:30-11:40</b>	Цайны завсарлага		
<b>11:40-13:00</b>	Комплаенсын соёлыг бий болгоход удирдах ажилтны оролцоо	Удирдах ажилтнуудад зохицуулалт болон санхүүгийн гэмт хэргээс үүсэх комплаенсын үр дагаврыг ойлгуулах, ёс зүйтэй ажилтны хүлээх үүрэг хариуцлага	Ш.Алтанцэцэг Санхүүгийн боловсролын HUB Зөвлөх
<b>15:00-16:30</b>	Бататгал хэлэлцүүлэг СЗХ-ны Санхүүгийн хүртээмжийн танхимд	Хэлэлцүүлгийн сэдэв: Удирдах ажилтны манлайлал-Комплаенсын хэрэгжилт, мөнгө угаалт улс орны болон компанийн түвшинд хэрхэн нөлөөлөх	Р. Амаржаргал Санхүүгийн боловсролын HUB, УЗ-ийн дарга